

БАТЛАВ.  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРТАН ВЭНХ-АМГАЛАН

2024 оны 12 дугаар сарын 16.-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ НИСГЭГЧГҮЙ НИСЭХ  
ХЭРЭГСЭЛ ЖОЛООДЛОГЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
“ДРОНОКОН-2024” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

**Нэг. Тэмцээний зорилго**

1.1. Монгол Улсад нисгэгчгүй нисэх хэрэгслийн спортыг хөгжүүлэх замаар дроны технологийг нутагшуулж, үндэсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй болон бусад салбарт үр дүнтэй ашиглах бодлогыг дэмжихэд энэхүү тэмцээний зорилго оршино.

**Хоёр. Тэмцээний зохион байгуулалт**

2.1. Тэмцээнийг 2025 оны 01 сарын 25, 26-ны өдрүүдэд “Буянт-Ухаа спорт цогцолбор”-т нээлттэй хэлбэрээр зохион байгуулна.

2.2. Тэмцээнийг дараах 4 төрлөөр явуулна. Үүнд:

- 2.2.1. Мэргэжлийн (FPV);
- 2.2.2. Сонирхогчдын (Commercial);
- 2.2.3. Тоглоомын (Toy);
- 2.2.4. Өөрөө угсралт (DIY).

2.3. Тэмцээний бүртгэл, мандат

2.3.1. Оролцогч 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн дотор цахим хаяг (<http://surl.li/ilydlr>)-аар бүртгүүлнэ.

2.3.2. Тэмцээний өдөр оролцогч цахим хаяг, утасны дугаараар бүртгэлээ баталгаажуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан гарын үсэг зурснаар тэмцээнд оролцох эрхтэй болно.

2.3.3. Тамирчдын нислэг үйлдэх дарааллыг сугалаагаар тогтооно.

2.4. Тэмцээний техникийн зөвлөгөөн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол цэргийн нэгдсэн холбооны байранд зохион байгуулагдана. Техникийн зөвлөгөөн байгуулагч: Т.Тайшир: 95692158, Б.Цэнд-Очир 88022878:

**Гурав. Тэмцээний ерөнхий дүрэм**

**3.1. Мэргэжлийн (FPV) төрөл**

3.1.1. мэргэжлийн (FPV) дрон нь олон улсын агаарын спортын холбооны FAI гаргасан дүрмийн дагуу 250м-ээс багагүй урттай олон улсын стандартад нийцсэн бүх тал нь хамгаалалтын тортой талбайд явагдана.

3.1.2. нисгэгч нар сугалааны дагуу хэсэгт хуваагдах ба нэг оролцогч нийт 3 нислэг үйлдэж хамгийн бага үзүүлэлттэй 2 үр дүнг дундажлаж хугацааг тооцно.

3.1.3. хэсэг тус бүрээс хамгийн бага үзүүлэлттэй нэг нисгэгч шалгарах ба нисгэгч нар гараанаас зэрэг гарж уралдана.

3.1.4. хамгийн бага хугацаанд бүх саадыг тойрч, замыг туулсан нисгэгч ялагчаар тодорно.

3.1.5. FPV дрон нисгэгчид бусад төрлийн тэмцээнд орохыг хориглоно.

3.1.6. талбайд зөвхөн нэг шүүгч нисгэгч нэвтрэх ёстой бага насын хүүхэд бол нэг харгалзах хүнтэй талбайд нэвтэрч болно.

3.1.7. виртуал зам нь Steam дээр байрлах The Drone Racing League Simulator -т байршуулсан MGL FPV RACING нэртэй байна.

3.1.8. тэмцээний төрөлд тавигдах техникийн шаардлага болон нарийвчилсан дүрэмтэй дараах линк <http://surl.li/nrnrg> -ээс татаж танилцана.

### **3.2. Сонирхогчдын (Commercial) дроны төрөл**

3.2.1. нисгэгчид тэмцээн зохион байгуулагдах өдөр хориотой бүсэд дрон нисгэх зөвшөөрөл тухайн үйлдвэрлэгч компаниасаа авсан байх ёстой.

3.2.2. нисгэгчид дарааллын дагуу нэг нэгээр гараанд гарч, зассан саад дундуур өгсөх, уруудах нислэг үйлдэж, тусгайлан бэлдсэн объектын бүтэн тойрог буюу 360 градусын бичлэгийг хийнэ.

3.2.3. даалгаврыг гүйцэтгэхдээ дроны өөрийн саад мэдрэгчийг ашиглаж болно. Харин дроны автомат нислэгийн горимыг ашиглахыг хориглоно. Жишээ нь: Activetrack.

3.2.4. ялагчийг тодруулахдаа нислэг гүйцэтгэсэн хугацаа болон ашигтай дүрсийн гүйцэтгэлээр дүгнэнэ. Нийт онооны үнэлгээг хугацаа 50%, ашигтай байдал 50% гэж тооцно.

3.2.5. нисгэгч 1-10 хүртэл оноо авах бөгөөд оноо тутамд 5 секунд нэмэгдэнэ. Хамгийн сайн бичлэг хийсэн нисгэгч хамгийн бага хугацааны нэмэгдэл ногдуулна.

3.2.6. талбайд зөвхөн нэг шүүгч, нисгэгч нэвтрэх ба бага насын хүүхэд асран хамгаалагч, харгалзагчтай талбайд нэвтэрч болно.

3.2.7. тэмцээний төрөлд тавигдах техникийн шаардлага болон нарийвчилсан дүрэмтэй дараах линк <http://surl.li/nrnrg> -ээс татаж танилцана.

### **3.3. Тоглоом (Toy) төрөл**

3.3.1. тоглоомын дэлгүүр, олон улсын худалдааны төвүүдэд зарагддаг бүх төрлийн дронууд оролцох боломжтой. Жин, овор хэмжээ, сэнсний диаметрийн хязгаарлалт байхгүй.

3.3.2. энэ төрөлд оролцох дроныг бүртгэл хэсэгт ангилж шалгах ба мэргэжлийн

болон сонирхогчдын төрлийн дрон ашиглахыг хориглоно.

3.3.3. нисгэгчид тусгайлан зассан талбайд нэг нэгээрээ хамгийн хурдан хугацаанд саадыг тойрч буцаж барианд ирэхээр уралдах ба оноог хугацаагаар тооцно.

3.3.4. талбайд зөвхөн нэг шүүгч, нисгэгч нэвтрэх ба бага насын хүүхэд асран хамгаалагч, харгалзагчтай талбайд нэвтэрч болно.

3.3.5. тэмцээний төрөлд тавигдах техникийн шаардлага болон нарийвчилсан дүрэмтэй дараах линк <http://surl.li/nrnrg> -ээс татаж танилцана.

#### 3.4. **Өөрөө угсрах (DIY) тэмцээн**

3.4.1. тэмцээний талбайд задалсан дроныг угсарч, тусгайлан бэлдсэн талбайд саадыг нэг бүтэн тойрог хийсэн хугацаагаар оноог тооцож, ялагчийг тодруулна.

3.4.2. дрон угсрах болон тохируулахад зааварлагч байж болно. Дроныг угсрах хугацаанд оноо өгөхгүй.

3.4.3. талбайд зөвхөн нэг шүүгч, нисгэгч нэвтрэх ба бага насын хүүхэд асран хамгаалагч, харгалзагчтай талбайд нэвтэрч болно.

3.4.4. тэмцээний төрөлд тавигдах техникийн шаардлага болон нарийвчилсан дүрэмтэй дараах линк <http://surl.li/nrnrg> -ээс татаж танилцана.

### **Дөрөв. Аюулгүй байдал, хориглох зүйлс**

4.1. Тэмцээний ерөнхий шүүгч тэмцээнд ашиглах тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгаж, хангалтгүй гэж үзвэл тэмцээнд оролцуулахгүй байх эрхтэй.

4.2. Нислэгийн бүсийг хязгаарлаж, бүх тийш хязгаартай үргэлжилсэн шулуун шугамыг нислэгийн бүс гэнэ. Шүүгч болон нислэг үйлдэх нисгэгч бүсэд байрлана. Тэмцээнийг зохион байгуулагчид, ээлжит нисгэгчид, үзэгчид нислэгийн шугамын гадна байрлана.

4.3. Нислэгийн аюулгүй байдал хангагдаагүй гэж үзвэл нисгэгч нислэгийг хойшлуулах, эсвэл дахин нислэг үйлдэх хүсэлтээ тэмцээний ерөнхий шүүгчид гаргаж болно. Энэ тохиолдолд шүүгч нарын нэгдсэн саналаар нислэгийг хойшлуулах, дахин нислэг хийх боломж олгож болно.

4.4. Загварыг гараас хөөргөх, гартаа буулгахыг хориглоно.

4.5. Нислэгийн үед төхөөрөмжийн эд анги салж унавал нислэгийг зогсоож, яаралтай буулгана.

4.6. Нислэгийн үед радио удирдлагын нэвтрүүлэгч болон хүлээн авагчийн туршилт, тохируулга хийхийг хориглоно.

4.7. Нислэг хийгээгүй нисгэгчид төхөөрөмжийн хөдөлгүүр асаахыг хориглох ба тэмцээний нислэгийн үед радио долгионы давхцал үүсгэсэн, хөдөлгүүр асаасан нисгэгчийг эхний удаа анхааруулга өгч, дахин алдаа гаргавал тэмцээнээс хасна.

4.8. Дроныг хамгаалалтын торноос гадуур нисгэхийг хатуу хориглоно. Хэрэв зөвшөөрөлгүй нисгэвэл тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

4.9. Талбайд гарах ээлжит нисгэгч зөвхөн шүүгчийн зөвшөөрлөөр дрон, удирдлагаа асааж нисэхэд бэлтгэнэ.

4.10. Түргэн тусlamжийн эмч болон шаардлагатай тоноглол бүхий түргэн тусlamжийн машин тэмцээний үеэр бэлэн байдалд байна.

### **Тав. Дүгнэх журам**

5.1. Нислэгийн хугацааг минут, секунд, долиор хэмжинэ (MM:SS:MS).

5.2. Нисгэгчд тэмцээний үер замын дагуу нислэг үйлдээгүй, зассан саадыг туулаагүй тохиолдолд +25 секундийн торгууль ногдуулна.

5.3. Шүүгчийн шийдвэртэй санал нийлэхгүй бол Ерөнхий шүүгчид бичгээр гомдол гаргаж болно.

5.4. Ерөнхий шүүгч нислэгийн бичлэгт үндэслэж гомдлыг шийдвэрлэх ба хэрэв бичлэг байхгүй тохиолдолд талбайн шүүгчийн шийдвэр хэвээр үлдэнэ.

### **Зургаа. Шагнал**

6.1. Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байрт алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал болон үнэ бүхий зүйлээр шагнана.

---оОо---